



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 18/09

Чингис хот

Үзлэг тандалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/08 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн 2025 оны 01 дүгээр сарын 08 ны өдрийн 25-622 тоот шинжилгээний дүнгээр Сариг багт гахайн африкийн мялзан өвчин оношлогдож хорио цээрийн дэглэмийг тогтоож, тус өвчинтэй тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд Хэрлэн сумын 1-6 дугаар багийн Гахайн аж ахуй эрхэлж буй иргэдийн гахайд нэг бүрчлэн үзлэг хийх ажлын хэсгийг байгуулсугай.


Ажлын хэсгийн ахлагч :Т.Сансарбаатар -Өндөрбилгэх МЭҮН-ийн
малын эмч

Нарийн бичгийн дарга :Б.Лхагвасүрэн -МАН-н үйлдвэрлэл,бүртгэл хариуцсан
мэргэжилтэн

Гишүүд:Э.Бямбадорж Мал эмнэлэг ариун цэврийн
Лабораторийн ийлдэс судлагч эмч /зөвшилцсөнөөр/

2. Дээрх үзлэг тандалтыг түргэн шуурхай зохион байгуулж шаардлагатай арга хэмжээг газар дээр авч хэрэгжүүлэн ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Т.Сансарбаатар)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.БОРГИЛ